



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/1304

Улаанбаатар хот

Нийтийн зорчигч тээврийн
үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит
аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын
2024 оны “Эдийн засгийн үр ашгийг
дээшлүүлэх зорилтот түвшин”
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2024 оны Зорилтот түвшнийг 1 дүгээр, үйлдвэрийн газруудын захирлын албан тушаалын цалингийн хэмжээг 2 дугаар, урамшууллын хэмжээг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шинэчилсэн цалинг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 5 үйлдвэрийн газрын захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” байгуулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлж, орлого, үр дүнг нэмэгдүүлэн, авлага, ер төлбөрийг бууруулж, үйл ажиллагааны менежментийг сайжруулан ажиллахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын захирал нарт үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 11 сарын 05 өдрийн
 А/Ж/ЗОА/8/2024 захирамжийн
 1 дүгээр хавсралт



НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
 ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫН 2024 ОНЫ ЗОРИЛТ

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Нийт орлого			Нийт зардал			Ашиг, алдагдал			Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	Нийт хөрөнгө оруулалтын дүн
	2023 оны зорилт	2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилт	2023 оны зорилт	2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилт	2023 оны зорилт	2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилт		
"Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ			33,152,954.5			35,443,661.7	-	-	(2,290,707.2)	1.07	2,110,000.0
"Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ			26,411,622.1			28,846,551.5	-	-	(2,434,929.4)	1.09	2,101,400.0
"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	59,316,356.1	57,378,470.0	53,451,414.6	64,922,211.8	60,275,674.6	60,629,653.3	(7,585,918.5)	2,252,001.4	(7,178,238.7)	1.13	3,968,000.0
"Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ			18,125,529.7			19,359,891.40	-	-	(1,234,361.7)	1.07	1,005,690.0
"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ			14,845,403.3			19,600,996.9	-	-	(4,755,593.6)	1.32	580,000.0
Нийт дүн	59,316,356.1	57,378,470.0	145,986,924.2	64,922,211.8	60,275,674.6	163,880,754.8	(7,585,918.5)	2,252,001.4	(17,893,830.6)		9,765,090.0